

“ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЧИН БОЛОН ХҮНИЙ НӨӨЦИЙГ БЭЛТГЭЖ БҮЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТҮҮНД ХИЙХ ШИНЭТГЭЛ” СЭДЭВТ СУДАЛГААНЫ ҮР ДҮН

CURRENT DEVELOPMENTS OF OPERATIONS AND PRODUCING HUMAN RESOURCE OF FORENSIC ORGANIZATION



Ц.Нямдорж. ШУТГ-ын Шүүхийн шинжилгээ судлалын төвийн дарга бөгөөд Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, хууль зүйн доктор, дэд профессор, цагдаагийн хурандаа
Nyamdorj.Ts. Head of Court Decision Execution Studies center and leading scientific researcher, Science and technology Department, Ph.D , Adjunct Professor, Police colonel

Abstract: We analyze on nowadays or past development of forensic organization's operations, structure, and how to produce its human resource in this paper. We also study the ways of developing it in the future, estimate and offer some recommendation. In addition, we compare other countries' educational systems of preparing human resource, structure and operations at their forensic science organizations in the USA, Russia, Netherland, Georgia, Estonia, New Zealand, Ireland and Republic of Korea.

Гэмт хэргийг илрүүлэх, аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хэв журам сахиулах, хэргийг мөрдөх, улс орны аюулгүй байдлыг хангах субъект болох Тагнуулын, Авлигатай тэмцэх, Цагдаагийн, Шүүхийн шинжилгээний, Иргэний харьяалал, шилжилт хөдөгөөний ерөнхий газар, Шүүхийн ба Прокурорын албаны албан хаагчид тус тусын хуульд давхардсан эрх үүрэгтэй боловч ажлын уялдаа холбоо муугаас шүүхийн нотлох баримт дутуу, түүнд хийвэл зохих шинжилгээг хийгээгүй буюу дутуу хийснээс хэрэг буцах, нотлогдохгүй ял завших, иргэн хилс хэрэгт ял зэмлэл хүлээх явдал байсаар байгаа ба дээрх албадын албан хаагчдын иргэндээ үйлчилдэг зарчмыг хуулинд тодорхой тусгах, ажиллах нөхцөл, баталгааг дээшлүүлэн зохицуулах, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, бусад хууль тогтоомжинд заасны дагуу Шүүхийн шинжилгээний байгууллагын өнөөгийн тогтолцоог боловсронгуй болгон дэлхийн улс орнуудын жишигт хүргэх, хөндлөнгийн хяналтын чиг үүрэгтэй, аль нэг байгууллагын хараат бус биеэ даасан ил тод зарчимд тулгуурласан байгууллага болох шаардлага байна.

Шинжлэх ухаан, технологи эрчимтэй хөгжиж буй өнөө үед манай улсын тухайд шүүхийн

шинжилгээний төрөл мэргэжлийн шинжээчдийг бэлтгэх сургалтын тогтолцоо нь өнгөрсөн зууны үеийн системээр байгаа бөгөөд эрс шинэчлэл хийх хэрэгцээ тулгараад байна. Шинжлэх ухаан шинэ шатанд гарч шинжилгээний арга аргачлал, техник хэрэгсэл шинэчлэгдэж, шинжээчдийн мэдлэг чадварт тавигдах шаардлага үндсээрээ өөрчлөгдсөн байна. Хууль сахиулах, шүүх шатны үйл ажиллагаанд шинжлэх ухааны үндэслэлтэй нотлох баримтын ач холбогдол өсөж байна. АНУ-ын Холбооны мөрдөх товчоо нь шүүхийн шинжээчдээ шаталсан сургалтын хэлбэрээр бэлтгэдэг бөгөөд тэдгээр нь дэлхийд хамгийн өндөр мэргэшсэн шинжээчид байдаг тул дэлхийн хөгжингүй улс орнууд шүүхийн шинжээчдээ бэлтгэхдээ АНУ-ын сургалтын бодлогыг загвар болгодог. Иймд манай улс шүүхийн шинжилгээний байгууллагын боловсон хүчнээ дэлхий нийтийн жишгээр бэлтгэх боломжийг судалж дүгнэлт, санал гаргасан байна.

Шүүхийн шинжилгээний байгууллагын үйл ажиллагаа, сургалтын орчныг судлах, тулгамдаж буй асуудлыг цогцоор тодорхойлж гаргах, “Бүтцийн шинэтгэл”, “Хүний нөөц, сургалтын бодлогын шинэтгэл”, “Техник, технологийн шинэтгэл” хийж, боловсронгуй болгох, хүний эрх, эрх чөлөөг

дээдэлсэн дэлхийн өндөр хөгжилтэй улс орнуудын жишигт хүргэх судалгааны үндэслэлтэй санал, зөвлөмж боловсруулах зорилго агуулсан судалгаа болсон байна.

Шүүхийн шинжилгээний байгууллагын үүсэл хөгжил, өнөөгийн бүтэц үйл ажиллагаа

Шүүхийн шинжилгээний байгууллагын үүсэл хөгжил: Монголын Шүүхийн шинжилгээний байгууллагын үүслийг 1921 оны Ардын хувьсгалын эхэн үеэс цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд гэрэл зураг нэвтэрч ирснээс гадна эрүүгийн гэмт хэргийн тоо бүртгэл хөтөлж, түүнийг боловсронгуй болгох ажил эхэлж, үүнтэй холбоотойгоор гэмт хэрэгтэн, сэжигтэн, яллагдагч нарын хурууны хээг авч бүртгэх ажил эхэлснээр тооцох болжээ.

Дотоод Явдлын Яамны сайдын 1940 оны 8-р сарын 30-ны өдрийн 661 тоот тушаалаар УЦСГ-ын гүйцэтгэх албаны хэлтэст хээ шинжээчийн орон тоо нэгийг баталсан ба 1940-1944 онуудад цагдан сэргийлэх байгууллагын гэмт хэргийн тоо бүртгэл, хурууны хээ авах, гэмт хэрэгтний гэрэл зураг авах ажлууд зохих хэмжээгээр өсөж иржээ.

Түүхийн эх сурвалжаар албан ёсоор 1944 оны нэгдүгээр сарын 12-ны өдөр Улсын цагдан сэргийлэх байгууллагын гүйцэтгэх хэлтэст ажиллаж байсан Зөвлөлтийн мэргэжилтний дэмжлэг тусламжтайгаар эрэлч нохойн групп, тоо бүртгэлийн групп, хээ шинжилгээ, гэрэл зургийн хэргийг харьяалан эрхлэх Шинжлэн магадлах техникийн 4-р тасгийг ДЯЯ-ны сайдын 14 тоот тушаал гарч, даргаар нь цагдан сэргийлэхийн бага дэслэгч Д.Адилбишийг томилсноор Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн суурь тавигдсан байна.

1944-1959 онд цагдан сэргийлэх байгууллагын үйл ажиллагаанд криминалистикийн онол, шинжлэх ухааны арга зүйг хэрэглэн гэмт хэрэг илрүүлэх ажилд гэрэл зураг, хурууны хээний шинжилгээг ашиглах, гэмт хэргийн тоо бүртгэлийг хөтөлж, түүнд дүн шинжилгээ хийх, мэргэжлийн боловсон хүчнээ бэлтгэн сургах ажилд ихээхэн анхаарал тавих болсон байна.

НАХЯ-ны сайдын 1968 оны 01-р сарын 23-ны өдөр “Илрээгүй гэмт хэрэгтэй тэмцэхэд ШҮТ-ийн арга ажиллагааг нэвтрүүлэх зарим арга хэмжээний тухай” 6 тоот тушаал гарч холбогдогч, сэжигтэн хүмүүсийн гарын таван хурууны бүртгэлийн сан бий болгох зааврыг баталжээ.

МАХН-ын Төв Хорооны 1975 оны нэгдүгээр сарын 16-ны өдрийн “Цагдан сэргийлэх байгууллагын ажлын тухай” 19 дүгээр тогтоолд “Хүний амины ба хулгайн хэргийг ирүүлэхэд шинжлэх ухаан, техникийн орчин үеийн ололтыг хэрэглэхийн тулд Шинжлэн судлах, мөрдөн хянах лаборатори байгуулах, түүнд ажиллах мэргэжлийн хүмүүсийг ЗХУ-д практикаар явуулж бэлтгэх, гэмт хэргийг шалгахдаа сэжиг таавраар биш

харин техник, шинжлэх ухааны аргуудыг хэрэглэж байх хэрэгтэй” гэж заасан нь гол удирдамж болсон байна.

МАХН-ын ТХ-ны УТТ-ны 1974 оны 24-р тогтоолыг үндэслэн БНМАУ-ын СнЗ-өөс УЦСЕГ-ын Шинжлэх Ухаан Техникийн хэлтэст хими, физик, биологийн лабораторид шаардлагатай техник хэрэгслийг гадаад орнуудаас захиалан авч лабораторийг байгуулахыг Улсын төлөвлөгөөний комисс, Гадаад худалдааны яам, НАХЯ-нд даалгажээ.

Ийнхүү тус хэлтэст БНАГУ-ын/хуучнаар/ тусламжтайгаар хими, физик, биологийн лаборатори байгуулагдаж, 1978 оны 01 сарын 25-нд лабораторийнхоо нээлтийг хийж байжээ.

Гэмт хэрэгтэй тэмцэхэд шинжлэх ухаан, техникийн ололтыг нэвтрүүлэх ажлын зохион байгуулалт, үр дүнг дээшлүүлэх, эрдэм шинжилгээний байгууллагын хүч тусалцааг авах ажлыг сайжруулах зорилгоор НАХЯ-ны сайдын 1988 оны 2 дугаар сарын 29-ний өдрийн А/11 тоот тушаалаар Шинжлэх ухаан, техникийн хэлтсийг Криминалистикийн Шинжилгээний төв болгон өргөтгөн зохион байгуулж 1988-1995 он хүртэл мэргэжилтэй боловсон хүчнээр хангах, шинжээчдийн мэргэжлийг дээшлүүлэх ажлын зохион байгуулахыг холбогдох байгууллагуудад даалгажээ.

1990-ээд оны эхээр Цагдаагийн шинжилгээний байгууллага нь мэргэжилтэй боловсон хүчний хувьд бэхжиж, ЗХУ-ын/хуучнаар/ ДЯЯ-ны Криминалистикийн дунд сургууль төгссөн 45, дээд сургууль төгссөн 85 мэргэжилтнийг хүлээн авч орон нутаг, дүүрэг болон төвд томилуулан ажиллуулсан ба тус төв нь гадаад, дотоодын дээд сургууль төгссөн мэргэжлийн боловсон хүчнээр үндсэндээ хангагдсан байна.

1992 онд батлагдсан Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу Монгол Улсын Их Хурлаас 1993 оны 12 дугаар сарын 13-ны өдөр баталсан “Монгол улсын цагдаагийн байгууллагын тухай хууль”-ийн 4-р зүйлийн 4-д “Цагдаагийн төв байгууллагын харьяанд цагдаагийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх сургууль, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах асуудлаар шинжилгээ судалгаа явуулах үүрэг бүхий байгууллага байж болно” гэж зааж өгсөн.

Ардчилал шинэчлэлийн энэ үед УЦСЕГ-ын Шинжлэх ухаан техникийн хэлтэс нь ЦЕГ-ын Криминалистикийн шинжилгээний төв болон өөрчлөгдсөн ба Цагдаагийн ерөнхий газрын даргын 1990 оны 8-р сарын 13-ны өдрийн 559 тоот тушаалаар орон тоог нь төвийн дарга 1, ахлах ажилтан арга зүйч 1, ахлах шинжээч 13, жинхэнэ шинжээч 5, гэрэл зурагчин, лаборант, бичиг хэрэг тус бүр 1, бүгд 23 орон тоотой байхаар баталсан байна.

Монгол Улсын Их Хурлын 1998 оны 18 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”-ийн 44-д “Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүх, прокурор болон хууль

сахиулах бусад байгууллагатай ажлын нягт уялдаа холбоотой криминалистик, шүүх эмнэлэг, санхүү нягтлан бодох бүртгэл зэрэг магадлан шинжилгээний байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг хянан үзэж, нэгдсэн зохион байгуулалтанд оруулан материаллаг баазыг бүрдүүлэх, бэхжүүлэх арга хэмжээ авна” гэж заасан байдаг гэгчлэн Шүүхийн шинжилгээний байгууллагын үүсэл хөгжлийн талаар товч түүхчлэн бичжээ.

Шүүхийн шинжилгээний байгууллагын өнөөгийн бүтэц, үйл ажиллагааны орчин

Монгол Улсын Засгийн газрын “Шүүхийн шинжилгээний алба байгуулах тухай” 2007 оны 270 дугаар тогтоолоор аймгийн цагдаагийн газар, хэлтсийн криминалистикийн шинжээч, аймгийн нэгдсэн эмнэлгийн шүүх шинжээч эмч нарыг нэгтгэн аймгийн Шүүхийн шинжилгээний алба, нийслэлийн дүүргүүд, Замын цагдаагийн газар, Төмөр замын цагдаагийн хэлтсийн криминалистикийн шинжээчдийг нэгтгэн Нийслэлийн Шүүхийн шинжилгээний албыг байгуулж аймаг, нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагийн статустай болгосон. Мөн тус хүрээнд Эрүүл мэндийн яамны харьяа Шүүх эмнэлгийн магадлах төв, Сангийн сайдын дэргэдэх Шүүх нягтлан бодох бүртгэлийн магадлах товчоо, Цагдаагийн ерөнхий газрын Шинжилгээний хүрээлэнг нэгтгэн Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнг байгуулсан.

Монгол улсын Хууль зүйн сайдын 2013 оны Б/01 тоот тушаалаар “Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн бүтэц, орон тооны дээд хязгаар”-ыг шинэчлэн улсын хэмжээнд 517 орон тоотой үйл ажиллагаа явуулахаар шийдвэрлэсэн байна.

Энэ нь Шүүхийн шинжилгээний байгууллагын хөгжүүлэн өргөжүүлэхэд эерэг үр дагавар авчирсан сайн тал ажиглагдаж Шүүхийн шинжилгээний байгууллага нь аль нэгэн байгууллагаас хараат бусаар үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн орчин бүрдсэн байна.

- Шүүхийн шинжилгээний байгууллага бие даасан агентлагийн статустай болсноор шинжээчдийн ур чадвар дээшлэх, эрдэмжих хандлага илтээр нэмэгдсэн байна. Тухайлбал, Шүүхийн шинжилгээний байгууллага 1944 онд Монголд үүсэн хөгжсөн түүхтэй боловч, НАХЯ, ЦЕГ-ын харьяанд байхдаа буюу 60 жилийнхээ түүхэнд 3 эрдэмтэнтэй байсан бол 2005 оноос хойш 9 жилийн дотор 5 доктор, 45 магистраар эгнээгээ тэлж, шинжээчдийн оюуны чадавх нэмэгдсэн байна.
- Хийгдэж байгаа шинжилгээний төрөл, чанар статистик тоон үзүүлэлт жилээс жилд нэмэгдэж байна.
- Алба хаагч нарын ажиллах орчин эрх зүйн баталгаа нь нэмэгдэж албандаа тогтвор суурьшилтай, ёс зүйтэй, үнэнч шударгаар хөдөлмөрлөх орчин бий


болсон.

- Санхүүгийн хараат бус болсноор шинэ техник, технологийг шинжилгээ судалгааны ажилдаа нэвтрүүлж ашиглах санхүүгийн баталгаатай орчин бий болсон.
- Удирдлагын шат дамжлага багассан байдал нь ажил, үүргээ гүйцэтгэх шуурхай байдлыг бий болгосон.
- 2003 онд Цагдаагийн Академид Эрх зүйч-Криминалистикийн шинжээчийн анги нээн ажиллуулсан явдал нь Монголдоо криминалистикийн мэргэжилтэн, Шүүхийн шинжилгээ, шинжээч нарын бэлтгэх бааз суурийг тавьж өгсөн байна.
- Монгол улсын Их Хурлаас “Шүүхийн шинжилгээний тухай хууль”-ийг 2009 онд батлуулсан явдал түүхэн ач холбогдолтой болсон. Энэ нь шүүхийн шинжилгээний байгууллага түүхэн хөгжлийнхөө зөв чиг хандлагыг тодорхойлсон хөгжингүй орнуудын түвшинд очсон, зарим орнуудын Шүүхийн шинжилгээний байгууллагаас түрүүлж явааг харуулж байна гэж онцлон тэмдэглэсэн ба дутагдалтай талыг дараахь байдлаар томъёолжээ. Үүнд:
- Шүүхийн шинжилгээний байгууллагыг нэг бүрчилсэн хэлбэрээр хөгжүүлээгүй.
- Шүүхийн шинжилгээний байгууллагыг хэт төвлөрүүлсэн.
- Бусад хууль сахиулах байгууллагад Шүүхийн шинжилгээний албадуудыг байгуулаагүй нь шинжилгээний байгууллагуудын өрсөлдөх боломжийг нээж өгөөгүй.
- Шүүхийн шинжилгээний төв байгууллагыг хөндлөнгийн хяналтын чиг үүрэгтэйгээр байгуулаагүй.
- Шүүхийн шинжилгээний байгууллагад туршилт судалгаа, эрдэм шинжилгээний чиглэлийг орхигдуулсан явдал байна.

Манай улсад өнөөдрийг хүртэл шүүхийн шинжилгээний цорын ганц байгууллага ажиллаж ирсэн ба цөөхөн тооны хэдэн шинжилгээ хийж, хийвэл зохих шинжилгээг хөрөнгө мөнгө, чадварлаг боловсон хүчин дутуу зэрэг шалтгаанаас болж 1980-аад онд хийж чаддаг байсан шинжилгээнүүдээ хийж чадахаа больж, хийгдэж байгаа шинжилгээнүүдийн шинжлэх ухаанч шинж чанар алдагдахад хүрээд байгаа нь гадаад, дотоодод шүүхийн шинжилгээний чиглэлээр мэдлэг боловсрол эзэмшсэн, ажлын туршлага хуримтлуулсан олон арван чадварлаг алба хаагчид мэргэжлээрээ тус байгууллагад ажиллахгүй байгаатай нэг талаар холбоотой тухай дурьдсан нь үнэний хувьтай гэж судлаачийн зүгээс санал нэг байна.

Олон улсын практик болон манай улсад урьд байсан тогтолцоогоор шүүх шинжилгээний байгууллага өөрийн судалсан гэмт хэргийн материалд гэмт хэргийг урьдчилан сэргийлэх ажиллагаа явуулах ёстой ч энэ нь манайд огт хэрэгжихгүй байгаа юм.

Шүүхийн шинжилгээний байгууллагын бүтцийн схем



Дээрхи бүтцийг судалж үзсэний үндсэн дээр Шүүхийн шинжилгээний төв байгууллагыг бие даасан, хараат бус, мэргэжлийн туслалцаа үзүүлдэг, хөндлөнгийн хяналтын чиг үүрэгтэйгээр байгуулах, мөн шаардлагатай бусад хуулийн байгууллагуудад


чиг үүргийг нь харгалзан лабораториуд байгуулах, орон нутгийн тухайд төвийн, баруун, зүүн, өмнөд бүсийн шүүх шинжилгээний лаборатори гэж бүсчилсэн хэлбэрээр хөгжүүлэх нь зүйтэй гэсэн зарим эрдэмтэн судлаачдын саналыг дэмжиж байна.

Шүүхийн шинжилгээний байгууллагад хийсэн шинжилгээний зарим тоон үзүүлэлт

Шүүхийн шинжилгээний байгууллагын 2009-2013 онд хийсэн шинжилгээнүүдийн тоон үзүүлэлт:


Шинжилгээний чиглэл, төрөл		2009	2010	2011	2012	2013
Криминалистикийн шинжилгээний чиглэлээр	Гарын мөр	3384	3684	3829	4392	5331
	Мөр судлал	627	714	789	1037	1178
	Гар бичмэл, гарын үсэг	700	850	770	1125	669
	Бичиг техник	484	558	296	430	398
	Дүр зураг	142	162	155	191	104
	Гал тээвсэг	424	161	268	255	271
	Тэсрэх төхөөрөмж	5	7	10	11	12
	Дүрс бичлэг	-	-	-	-	54
	Автотехник	-	-	-	-	51
	Бүгд	5766	6136	6117	7441	8032

Хими, физик, биологи, ДНХ, бактериологийн шинжилгээний чиглэлээр	Хими	3676	3740	5012	5194	4747
	Физик	206	149	194	245	156
	Биологи	7044	6274	6279	5509	5281
	ДНХ	133	205	304	419	546
	Бактериологи	446	534	611	662	899
	Бүгд	11505	10869	12400	12029	11629
Шүүх эмнэлгийн шинжилгээний чиглэлээр	Цогцост хийсэн шинжилгээ	2811	3479	3767	4267	3521
	Хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ	20746	20835	23183	26249	29370
	Хүний биед хийсэн бусад шинжилгээ /бэлгийн холбогдолтой, нас тогтоох/	683	1067	1092	931	1099
	Хэргийн материалаар хийсэн шинжилгээ	953	944	1073	1165	1200
	Шарилд хийсэн шинжилгээ /эксгумаци/	29	21	26	25	25
	Гистологийн шинжилгээ	2274	2703	2800	3514	2888
	Бүгд	27496	29049	31941	36151	38103
Шүүх эдийн засгийн шинжилгээний чиглэлээр	Татвартай холбоотой	20	37	30	87	82
	Өмч хувьчлалтай холбоотой	6	6	-	-	-
	НД-ын шимтгэлтэй холбоотой	-	1	2	4	12
	Бэлэн мөнгөтэй холбоотой	39	36	48	73	87
	Эд хогшил, бараа	28	45	25	2	17
	Бусад зөрчил	28	18	36	19	18
	Бүгд	121	143	141	278	216
НИЙТ		44888	46197	50599	55899	57980



Шинжилгээний чиглэл

Хэргийн газрын үзлэгт оролцсон байдал /2007–2011 он/

**Шинжээчдэд оногдож буй шинжилгээний тоон үзүүлэлт**

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн шинжилгээний чиглэлийн хэлтэс лабораториуд буюу Криминалистикийн шинжилгээний хэлтэс,

Шүүх эмнэлгийн шинжилгээний хэлтэс, Тусгай шинжилгээний хэлтэс, Эдийн засгийн шинжилгээний хэлтэст 2013 оны байдлаар нийт 121 шинжээч, лаборант, оператор, туслах ажилтан ажиллаж байна.

Криминалистикийн шинжилгээний хэлтэс	Шүүх эмнэлгийн шинжилгээний хэлтэс	Тусгай шинжилгээний хэлтэс	Эдийн засгийн шинжилгээний хэлтэс
46 шинжээч	45 шинжээч	22 шинжээч	8 шинжээч

2012 онд хийсэн шинжилгээг шинжээчдийн тоонд харьцуулбал:

Шинжилгээний төрөл	Криминалистикийн шинжилгээ	Шүүх эмнэлгийн шинжилгээ	Хими, биологи, физикийн шинжилгээ	Эдийн засгийн шинжилгээ
Нийт шинжилгээ	4042	17783	12691	278
Нэг шинжээчид оногдох шинжилгээ	87	395	576	35

Хүрээлэнгийн төвийн лабораторийн шинжээчид өөрсдийн эзэмшсэн мэргэжил, мэргэшлийн дагуу шинжилгээ хийхээс гадна хүний амь нас хохирсон хэргийн газрын үзлэгт багийн зохион байгуулалтаар оролцдог. 2012 онд нийт 2454 удаа хэргийн газрын үзлэгт мэргэжилтнээр оролцсон байна.

Дээрх тоон үзүүлэлтээс харахад шүүхийн шинжилгээний байгууллагад хийгдсэн шинжилгээний төрөл, тоон үзүүлэлт жилээс жилд өссөн харагдаж байгаа нь тухайн байгууллагыг орчин үеийн техник хэрэгсэл, өндөр мэргэжлийн боловсог хүчнээр хангаж бэхжүүлэх нь зүйтэй гэсэн дүгнэлтэнд хүрч байна.

Гадаад улс орнуудын Шүүхийн шинжилгээний байгууллагын бүтэц, үйл ажиллагаанд хийсэн судалгааны үр дүнд дараахь дүгнэлтэнд хүрсэн байна. Үүнд:

Дэлхий нийтийн чиг хандлага гэмт хэрэгтэй тэмцэхдээ шинжлэх ухаан техник, технологийг өргөнөөр ашиглах, шинэ дэвшилтэт техник технологийг бүтээн гаргах, улс орон гүрнүүд хамтран ажиллах, мэдээлэл солилцож бие биенээсээ суралцаж ололт амжилтаа бэхжүүлэх өргөн бололцоо нээгдсэн өнөө үед гадаадын өндөр хөгжилтэй улс орнуудын Шүүхийн шинжилгээний байгууллагын бүтэц зохион байгуулалт, чиг үүргийг судлан өөрийн орны

Шүүхийн шинжилгээний байгууллагын түвшин ямар түвшинд байгаа, юу хийж болох талаар судласан нь судалгааны ажлын нэг хэсэг болсон байна.

Энэ хүрээнд гадаадын 42 орны Шүүхийн шинжилгээ байгууллагын бүтэц, үйл ажиллагааг судалсан ба үүнээс АНУ, ОХУ, Нидерланд, Гүрж, Эстони, Шинэ Зеланд, Ирланд, БНСУ зэрэг 8 орныг онцлон авч судалсан байна.

Судалгаанд хамрагдсан 42 улс орнуудын нийтлэг шинж нь Шүүхийн шинжилгээний байгууллагыг хэт төвлөрсөн бус задаргаа сайтай хууль хяналтын, төрийн байгууллагуудаас гадна хувийн компаниуд шүүхийн шинжилгээг хийдэг байна.

Улс орон бүр өөрийн орны хууль зүйн салбарын эрх зүйн зохицуулалтанд тохирсон шинжлэх ухаан, техникийн дэвшил, оновчтой зөв инновацид тулгуурласан Шүүхийн шинжилгээний байгууллагыг хараат бус, өрсөлдөх чадамж бүхий олон төрлийн салбар бүрийн онцлог үйл ажиллагаанд тохирсон Шүүхийн шинжилгээний байгууллагуудын лабораторитой байх бөгөөд байгууллагын тогтвортой байдлыг хангасан Шүүхийн шинжилгээний байгууллагын хуультай байна.

Ямар нэгэн хууль сахиулах байгууллагаас хамааралгүй, хөндлөнгийн, бие даасан буруутгах болон хамгаалах 2 талын дунд тэгш эрхтэй шинжилгээний байгууллага байснаар хуулийн өмнө хүн бүр эрх тэгш байх зарчмыг хангах том тогтолцоог бий болгож байгаа юм. Ийм систем руу сүүлийн жилүүдэд олон орон шилжиж орж байгаагийн жишээ нь Нидерланд, Эстони, Гүрж, Турк, Тайланд, Казакстан зэрэг улсууд.

Энэ нь АНУ-ын Хууль сахиулах байгууллагын лабораториудаас гадна, муж улсуудын бие даасан лабораториуд, хувийн лабораториудын үйл ажиллагаанаас жишээ авч, өөрийн онцлогт тохируулан нутагшуулсан жишээ юм. Мөн талуудын тэгш байдлыг эрх зүйн зохицуулалтаар шийдвэрлэсэн жишээ нь АНУ-ын Арканзас мужийн Криминалистикийн лаборатори зөвхөн

хууль сахиулах үүрэгтэй агентлагуудаас ирүүлсэн хүсэлтээр шинжилгээ хийдэг байсан боловч хууль сахиулах байгууллагуудын 79-р чуулганы үеэр Улсынхаа өмгөөлөгчдийн хороонд /Public Defender Commission/ лабораторийн үйлчилгээг ашиглах эрх мэдэл өгсөн явдал гэж дурьджээ.

Шүүхийн шинжилгээний байгууллагын эрх зүйн шинэтгэлийн хүрээнд: Манай улс Монгол улсын Их хурлын 2009 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар “Шүүхийн шинжилгээний тухай хууль”-ийг баталсан нь шүүхийн шинжилгээний байгууллагын хувьд үйл ажиллагааны зарим чиг үүргийг тодорхойлж, байгууллагын тогтолцоог баталгаажуулсан явдал нь дэлхий нийтийн чиг хандлагатай тохирч байгаа хэдий ч “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр”-т “Шүүх, хууль хяналтын байгууллагын тогтолцооны шинэчлэлт хийх” ажлын хүрээнд шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо, үйл ажиллагаа хамрах хүрээнд бодит ажил хийж “Шүүхийн шинжилгээний тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулж шинэчлэн, боловсронгуй болгох шаардлага гарч байгааг онцлон тэмдэглэсэн байна.

Монгол улсад шүүх шинжилгээ хийдэг Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгээс гадна Шүүгчийн захирамжаар шинжилгээ хийсэн 110 төрийн ба төрийн бус байгууллагууд байна.

Энэ нь шүүх шинжилгээ хийлгэх эрэлт хэрэгцээ нэмэгдэж байгаа, шинжилгээг хийх төрийн ба төрийн бус байгууллагуудад шүүх шинжилгээ эрхийг хуулиар олгохыг цаг үе шаардаж байгааг харуулж байна.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн лабораториудад одоогоор хийх боломжгүй байгаа зарим төрлийн шинжилгээнүүдийг шинжилгээний болон эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, лабораториуд цөөнгүй хийж байгаа жишээг 2012 онд 110 байгууллага Шүүгчийн захирамжаар шинжилгээ хийж акт, дүгнэлт гаргасныг хүснэгтээр харуулсан нь:

Д/д	Байгууллага, аж ахуйн нэгжийн нэр	Баянзүрх	Баянгол	Багануур	Налайх	Сонгинохайрхан	Сүхбаатар	Хан-Уул	Чингэлтэй	НИЙТ
1	Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн	40	46		6	30	7	27	34	190
2	Итгэл эстимент ХХК	20	21			5	4	3	2	55
3	Хөрөнгийн үнэлгээний төв ХХК	20	16	7	3	5	8	29	19	107
4	Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс	1								1
5	Дельта Мон ХХК	8								8

6	Хүүхдийн эрхийг хамгаалах Үндэсний төв	4	7			1	2			14
7	Нийслэлийн газрын алба	1				2				3
8	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв	1								1
9	Нийслэлийн хүүхдийн төлөө газар	1					2	1	6	10
10	Баянзүрх дүүргийн газрын алба	2								2
11	Замын цагдаагийн газар	9	11			7	1	11	8	47
12	Бэст эмтимэйст	2								2
13	Нийгмийн хөгжлийн хэлтэс	1								1
14	ШУТИС	3							2	5
15	БЗД- ийн Засаг даргын тамгын газар	1								1
16	ЛЕНДС ХХК	2								2
17	Хүний эрхийн үндэсний төв	2								2
18	Топ сүрвэй ХХК	1						1		2
19	Нийслэлийн мэргэжлийн хяналтийн газар	1				3	7		4	15
20	Нийслэлийн мэргэжлийн улсын хяналтын газар	1								1
21	ЦЕГ- ийн харьяа Мэдээлэл , шуурхай удирдлагын газар	1								1
22	БЗД-ийн Нийгмийн хөгжлийн хэлтэс	1								1
23	Инержи Геодези ХХК	1					3			4
24	Чингэлтэй дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтэс	1								1
25	Сурфасе Сүрвэй ХХК	1								1
26	Геоцацраг ХХК	1								1
27	Оюуны өмчийн газар	1	2							3
28	Барилга архитектур корпораци ХХК	1								1
29	Барилга хот байгуулалт, геодези, зураг зүйн газар	1								1
30	Жин мандал ХХК	1								1
31	Англи хэлний хөтөлбөрийг магадлан итгэмжлэх холбоо	1								1
32	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв	1	1				1	2	1	6
33	Инержи ХХК	1								1
34	Архитектур	1								1
35	Гал түймэртэй тэмцэх газар	1								1
36	Тоб сүрвэй ХХК	1								1
37	Газрын харилцаа геодези зураг зүйн газар	3			1	4	2	5	2	17
38	Хүүхийн эрхийн үндэсний төв		7				2			9
39	Бэсгэ		7				4			11
40	Мэргэжлийн хяналтын газар		15		1					16
41	Итгэлт Аудит		2							2
42	Нийслэлийн онцгой байдлын газар		1							1
43	Нийслэлийн захирагчийн ажлын албаны харьяа Сургалт судалгаа хөрөнгө оруулалт барилга захиалагчийн алба		3							3
44	Эм А Энд Би ХХК		1							1

45	Хөтөч од ХХК	1							1
46	Барилгын хөгжлийн төв	3							3
47	ШУТИС -ийн Механик инженерийн сургууль	1							1
48	ШУТИС- ийн Геологи газрын тосны газар	1							1
49	Сууц өмчлөгчдийн холбооны дээд зөвлөл	1							1
50	Барилга хот байгуулалтын яамны харьяа Сургалт судалгаа, хөрөнгө оруулалт , барилга захиалагчийн алба	1							1
51	ЗЦН	1							1
52	Усны газар	1							1
53	Мишээл Од Аудит ХХК	2							2
54	Улсын бүртгэлийн ерөнхий газар	2							2
55	Далай ван аудит	2			1			2	5
56	Монгол банк	1							1
57	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв	1				1	2	1	5
58	Санхүү эдийн засгийн дээд сургууль	1							1
59	Лайн аудит ХХК	3							3
60	Монголын удирдлагын нягтлан бодогчдын институт	2							2
61	Шүүх эмнэлгийн эс судлалын төв		4						4
62	ШШҮТ -ийн криминалистик шинжилгээний хэлтсийн бичиг судлалын төв		1						1
63	Хүүхэд хөгжлийн үндэсний төв			1					1
64	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар			1					1
67	Сонгинохайрхан дүүргийн газрын алба				2				2
68	"Ти Эс Ай Аудит " ХХК				1				1
69	Монгол банкны Хяналт шалгалтын газар Зээлийн мэдээллийн сан				1				1
70	Шинэ Кадастр ХХК				1				1
71	Хөрөнгийн үнэлгээний - Дамно ХХК				1				1
72	Сонгинохайрхан дүүргийн Мэргэжлийн хяналтын газар				1				1
73	Мега марз ХХК				1				1
74	Улсын мэргэжлийн хяналтын газар				1				1
75	Далай ван - Аудит ХХК				1				1
76	Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Механик инженерийн сургуулийн тээврийн хэрэгслийн баг				1				1
77	Санхүүгийн зохицуулах хорооны Бичил бизнесийг дэмжих байгууллага				1				1
78	Дархан - Уул аймгийн Мэргэжлийн хяналтын газар				1				1
79	Ситико аудит ХХК					4			4
80	Инженер геодези ХХК					3			3
81	Дамно ХХК					1			1

82	Сэтгэц эмгэг судлалын төв						1			1
83	Авто замын газар						1			1
84	МШХХТГазар						3			3
85	Нийслэлийн газрын алба						3			3
86	МУИС -ийн гадаад хэлний тэнхим						1			1
87	Нийслэлийн байгаль хамгаалах газар						1			1
88	МҮХАҮТ - ийн экспорт , импортын барааны хянан шалгах газар						1			1
89	Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар							3		3
90	Төмөр замын газар							1		1
91	Эрчим хүчний удирдах газар							1		1
92	Зам тээврийн яамны харьяа Төмөр замын болон далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар							1		1
93	Стандартчлал хэмжил зүйн газар							1		1
94	Барилгын материалын лаборатори , Барилга байгууламж бүтцийн лаборатори							1		1
95	Авто замын газрын судалгаа шинжилгээ норм нормативийн хэлтэс							1		1
96	Харилцаа холбооны зохицуулах хороо							1	1	2
97	Арьс ширний эрдэм шинжилгээний хүрээлэн							1		1
98	Хан - Уул дүүргийн газрын алба							1		1
99	Вакум цонх үйлдвэрлэгчдийн холбоо							1		1
100	Монголын Барилгын зөвлөх үйлчилгээний төв корпораци							1		1
101	Эс Ар Кеи Косалтинг ЭМ Жи Эл ХХК							1		1
102	Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ХК							1		1
103	Доктор авто сервис ХХК							1		1
104	Хөрөнгийн үнэлгээ төслийн Лэндс ХХК								19	19
105	Эм эм си эс ХХК								2	2
106	ХААИС-ийн Механик инженерийн сургууль								1	1
107	Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газар								1	1
108	Нийслэлийн мал эмнэлгийн газар								1	1
109	Хан - Уул дүүргийн засаг даргын тамгын газар								1	1
110	Библийн сургалтын төв								1	1
111	Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн								1	1

Эдгээр байгууллагуудаар хийлгэсэн шинжилгээнүүд нь шүүхийн шинжилгээний арга зүйгээр хийгдээгүй ба акт, оношилгооны чиглэлээр хийгдсэн байгаа нь Шүүхэд нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэх үнэлэмж нь бага, хүний эрх, эрх чөлөөг хангах асуудал эргэлзээтэй байна гэсэн дүгнэлт хийжээ.

Судалгааны явцад Монгол улсын Гаалийн тухай хуулийн "Гаалийн хяналтыг хэрэгжүүлэх үед хийх магадлан шинжилгээ" гэсэн бүлэгт "магадлан шинжилгээ хийх, шинжээч томилох тухай гаалийн байгууллагын шийдвэрийг өмчийн аль ч хэлбэрийн байгууллага хүлээн авч хэрэгжүүлнэ. Магадлан шинжилгээг мэргэжлийн хувийн өмчийн болон төрийн бус байгууллага, эсхүл бие даасан шинжээчээр гэрээний үндсэн дээр

гүйцэтгүүлж болох бөгөөд энэ тохиолдолд магадлан шинжилгээний төлбөрийг мэдүүлэгч хариуцна” гэсэн утга агуулгатай заалтууд оруулсан байгаа нь үнэн чанартаа шинжилгээг өргөн хүрээнд хамруулах талаар маш тодорхой зааж өгсөн, түүнчлэн хувийн хэвшлийн шинжилгээний байгууллагыг хүлээн зөвшөөрсөн нь шинжилгээний чанар болон өрсөлдөөн хөндлөнгийн хяналтыг дэмжсэн дэлхий нийтийн чиг хандлагад нийцсэн зүйл заалт болсон байна.

Судалгаанаас үзэхэд Монгол улсын шүүхийн шинжилгээний байгууллага нь олон улсын жишгээр Шүүх шинжилгээ зүйн (forensic science) тогтолцоонд ойртож байгалийн шинжлэх ухаануудыг түшиглэж лабораториудыг нэгтгэн цаашид олон улсын түвшинд хүрч ажиллах байгалийн шинжлэх ухаанд суурилсан криминалистик, биологи, шүүх эмнэлэг, хүнсний бараа материал, геологи, уул уурхай, барилга зам, онцгой байдлын бүх төрлийн техник, технологи, эдийн засгийн гэх мэт олон улсын нийгмийн харьцаанд үүсдэг маргаантай асуудалд шинжлэх ухааны үндэслэлтэй шинжилгээ хийж дүгнэлт өгөх чадамжтай лаборатори бүхий байгууллага болох явдал дэлхий нийт даяаршиж буй өнөө цагт зайлшгүй чухал болоод байна гэж ирээдүйгээ харсан дүгнэлт хийжээ.

Бидний үзэж байгаагаар шүүх шинжээчийг бэлтгэж байгаа тухайд:Өнгөрсөн зууны 70,80-аад оны үед Шүүхийн шинжилгээний байгууллага үндсэн боловсон хүчин болох криминалистикийн шинжээчээ ЗХУ-ын/хуучнаар/ ДЯЯ-ны Академи, дээд, дунд сургуулиудад, химич, биологич, физикч мэргэжилтнээ гадаад, дотоодын иргэний их, дээд сургуулиудад бэлтгэн, тухайн байгууллагадаа мэргэшүүлэн ажиллуулж ирсэн түүхэн уламжлалтай.

Ардчилалын үе эхэлсэн 1990 оны үеэс ОХУ-д криминалистикийн шинжээчийг бэлтгэхээ больж, 90-ээд оны сүүлээс криминалистикийн мэргэжилтэн бэлтгэх шаардлага гарч, Цагдаагийн академид богино хугацааны дамжаагаар 200 гаруй криминалистикийн мэргэжилтэн бэлтгэн орон нутаг, дүүргийн Цагдаагийн газар, хэлтсүүдэд томилон ажиллуулж байжээ.

2003 оноос Цагдаагийн академид “Эрх зүйч-криминалистикийн шинжээч”-ийн ангийг нээснээс хойш 5 удаагийн төгсөлтөөр 115 шинжээчийг бэлтгэн практикт ажиллуулж байна. Мөн 2006 оноос ОХУ-ын ДХЯ-ны Академид цөөн тоогоор бэлтгэж байна.

Судалгаанаас үзэхэд, криминалистикийн шинжээч бэлтгэж байгаа хичээлийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах, байгалийн шинжлэх ухааны /хими, физик, биологи/ хичээлийн цагийг нэмэгдүүлэх, цаашлаад дээд болон түүнээс дээш химич, физикч, биологич, эмч, инженер, эдийн засагч болон хэлний мэргэжилтэй хүмүүсийг сонгон шалгаруулан авч эрх зүй, шүүх шинжилгээ хийх арга зүйд тусгай хөтөлбөрийн дагуу богино хугацаагаар сурган шүүх шинжээчээр ажиллуулах хэлбэрийг сонгон

хэрэгжүүлбэл шүүх шинжээч бэлтгэх эдийн засгийн хэмнэлттэй болох ба шинжээчийн дүгнэлтэд суурь мэргэжлийн зүгээс ахиц гарах талтай гэж үзэж байна.

Дээрх судалгааны үр дүнд дараахь дүгнэлт хийж байна.

Хууль зүйн яамны Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн нь шинжилгээ хийж дүгнэлт гаргахаас гадна хэргийн газрын үзлэгт оролцож ул мөр, эд мөрийн баримт илрүүлж бэхжүүлэх, эрэн сурвалжлах сан цуглуулга бүрдүүлж ашиглах үүргийг давхар хүлээж байгаа нь байгууллага, алба хаагчдын ачааллыг нэмэгдүүлж, хэрэг илрүүлэх чиг үүрэг бүхий байгууллагуудын үндсэн үүргээс хуваалцсан байдал судалгаанаас харагдаж байна.

Хэргийн газрын үзлэгээр ул мөр цуглуулах, хэргийн газрын гэрэл зураг авах, шуурхай эрэн сурвалжлах зорилгоор гарын мөр, хонгио, хошуу, эзэнгүй цогцосны мэдээллийн сан бүрдүүлж ашиглах ажиллагааг хэрэг илрүүлэх үндсэн чиг үүрэг бүхий байгууллага эрхлэн гүйцэтгэдэг, улмаар хэрэг илрүүлэх чиг үүрэгтэй байгууллага дотроо заавал “шүүх шинжилгээний” гэсэн бүтцэд төвлөрүүлэхгүйгээр шийдвэрлэсэн жишээ түгээмэл байна. Тухайлбал, АНУ-ын Виржиниа муж улсын Цагдаагийн газрын бүтцэд байх гарын хээний сан (AFIS), полиграф, дижитал гэрэл зураг, хэргийн газрын үзлэгээр биет нотлох баримт цуглуулах үүргийг тус тусдаа хэлтсүүдэд хуваарилсан байна.

Шүүхийн шинжилгээний тухай хууль нь Монгол улсын хэмжээнд шүүх шинжилгээ хийхтэй холбоотой харилцааг зохицуулах, зөвхөн шүүх шинжилгээний процессийн хууль байх нь тохиромжтой юм. Учир нь өнөөгийн мөрдөж буй Шүүхийн шинжилгээний тухай хуулинд тодорхой байгууллагын үйл ажиллагаа, эрх хэмжээг тодорхойлсон нь цаашид бусад хууль сахиулах болон судалгаа, шинжилгээний байгууллагад шүүх шинжилгээ хийх, төрийн бус шүүх шинжилгээний байгууллага байгуулагдах боломжийг хааж байна.

Судалгааны явцад Монгол улсын Шүүх шинжилгээний байгууллагын тогтолцоо, шинжилгээ хийх үндэслэл нь Монгол улсын Үндсэн хуулинд заасан ардчилсан ёс, эрх чөлөө, тэгш байдлын зарчмыг хангахгүй байна гэсэн дүгнэлтэнд хүрлээ. Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлд “Шүүхийн шинжилгээ хийх үндэслэл нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, төрийн эрх бүхий байгууллагын хүсэлт байна” гэж заасан нь талуудын тэгш эрхийг зөрчсөн заалт болж байна. Хууль сахиулах байгууллагууд нь гэмт хэрэг, зөрчлийг шалгаж шийдвэрлэхдээ шинжилгээний байгууллага, шинжээчийн дүгнэлтийг тухайн иргэн, хуулийн этгээдийг цагаатгах, буруугүй болохыг тогтоохоосоо илүү яллах, буруутгах хэрэглэгдэхүүн болгон ашигладаг.

Судалсан гадаад улс орнуудын Шүүхийн шинжилгээний байгууллагууд өөрийн орны болон бүс нутаг, дэлхийн хэмжээний стандартчлалын байгууллагаар магадлан итгэмжлэгдсэн байна. Иймд манай улсын Шүүхийн шинжилгээний байгууллага, лабораториуд магадлан итгэмжлүүлэх шаардлагатай байна.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд уламжлалт шинжилгээнүүдээс гадна авто техникийн шинжилгээ, шүүх дижитал судлалын шинжилгээний лаборатори байгуулан шинжилгээ хийж эхэлж байгаа нь сайшаалтай ба цаашид лабораториудын уялдаа холбоог сайжруулах, шинэ төрлийн шинжилгээг хийх нөхцөл бүрдүүлэхийн тулд лабораториудын бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх зайлшгүй шаардлагатай байна.

Судалгааны явцад хүрсэн дүгнэлтэнд тулгуурлан дараахь үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

Шүүхийн шинжилгээний тухай хуулинд заасан үндсэн чиг үүрэг болох шинжилгээ хийж дүгнэлт гаргах үйл ажиллагааг сайжруулах, ажилтнуудын ачааллыг хөнгөвчлөх, шинжээч зөвхөн шинжилгээ, судалгааны ажилд анхаарлаа хандуулдаг болгохын тулд Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн тогтолцоог өөрчилж хэргийн газрын үзлэгээр биет нотлох баримт цуглуулах, хэргийн газарт зураг авах, эрэн сурвалжлах зорилгоор гарын мөр, хонгио, хошуу, эзэнгүй цогцосны мэдээллийн сан бүрдүүлж ашиглах ажиллагааг хэрэг илрүүлэх үндсэн чиг үүрэг бүхий байгууллагад шилжүүлэх.

Шинэ технологи, шинэ төрлийн гэмт хэргийг дагасан шинэ нотлох баримтууд бий болж байгаа өнөө үед шүүх шинжилгээний байгууллага нь зөвхөн шинжилгээ хийж дүгнэлт гаргахаас гадна эрдэм шинжилгээ, судалгаа явуулах, үр дүнг нь турших, практикт өргөнөөр нэвтрүүлэх нэгж/эрдэм шинжилгээний хүрээлэн/-тэй болох.

Шүүхийн шинжилгээний тухай хууль нь Монгол улсын хэмжээнд шүүх шинжилгээ хийж, дүгнэлт гаргах үйл ажиллагааны явцад үүсэх харилцааг зохицуулахаар өөрчлөх, тодорхой байгууллагын эрх хэмжээг зохицуулсан хэсгийг хүчингүй болгох.

Шүүх шинжилгээний уламжлалт төрлүүдээс гадна Инженер техникийн, Митохондрын ДНХ-ийн, Хөрс, ургамал судлалын, Эдийн засгийн шинжилгээний шинэ төрлүүдийн, Материалын, Хүнсний, Газрын тосны, Мэдээллийн технологийн, Шүүх дижитал судлалын (компьютерийн програм хангамж, электроник, гар утас судлал, сүлжээ судлал), эмнэлэг-криминалистикийн, антропологийн, цацраг идэвхт бодисын, сэтгэц судлалын, тэсрэх төхөөрөмж, тэсрэх бодис, үнэр судлалын зэрэг лабораториудыг шинээр бий болгох.

Шинжилгээг гардан хийдэг, шинжилгээ хийхэд туслах үүрэгтэй оролцдог (лаборант, туслах ажилтан, бага эмч зэрэг) хүний нөөцийг нэмэгдүүлэх, удирдлагын аппаратыг багасгах шаардлагатай бөгөөд үүний тулд хүний нөөцийн бодлого боловсруулан, төлөвлөгөө гарган мөрдөж ажиллах, шинжээчийн шууд болон шууд бус удирдлагыг аль болох бага байлгах зарчим баримтлах шаардлагатай байна.

Шүүх шинжээч бэлтгэж байгаа одоогийн хэлбэрт өөрчлөлт оруулах/криминалистикийн шинжээч бэлтгэж байгаа хичээлийн хөтөлбөрт мэргэшүүлэх хичээлийн цагийг нэмэгдүүлэх, эсвэл шаардлагатай дээд мэргэжилтэй боловсон хүчинг авч эрх зүй, шинжилгээ хийх арга зүйд сурган авч ажиллуулах/зэрэг саналуудыг энэхүү судалгааны ажлын үр дүн гэж томъёолж байна.